

ДОТООД АУДИТ, МОНИТОРИНГИЙН ГАЗРЫН
2022 ОНЫ ХИЙСЭН АЖЛЫН ТАНИЛЦУУЛГА

2022 оны 12 дугаар сарын 20

Улаанбаатар хот

Дотоод аудит, мониторингийн газар нь Монгол Улсын Засгийн газраас батлагдсан бодлогын баримт бичгийн хэрэгжилт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, нийгмийн даатгалын салбарын хууль тогтоомжийн биелэлт, газрын болон хэлтсүүдийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийж, үнэлэлт, дүгнэлт зөвлөмж гаргаж, холбогдох газар хүргүүлэх, бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагааны үр дүнг зөв үнэлэх, удирдлагыг бодитой мэдээллээр хангах зорилго, ажиллах чиг үүргийн дагуу ажлаа төлөвлөн, биелэлтэд нь хяналт тавин ажиллаж байна.

Тус газар нь тайлант хугацаанд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖПЫН ТАЛААР**1.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх зорилтын хүрээнд:****1.1.1. Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, ҮАБЗ-ийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;**

Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, ҮАБЗ-ийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцад 2021 оны жилийн эцэс, 2022 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.

Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд хэрэгжиж буй 36 хууль тогтоомж, дээд газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн 50 заалтын биелэлтийг 2021 оны жилийн эцсийн байдлаар 98.0 хувь буюу “Бүрэн хангалттай” гэж үнэлж, үнэлгээний тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 01/28 дугаар албан бичгээр, 2022 онд 21 хууль тогтоомж, дээд газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн 41 заалтын биелэлтийг 2022 оны хагас жилийн байдлаар 97,3 хувьтай үнэлж, үнэлгээний тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 01/1054 дүгээр албан бичгээр Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн.

1.1.2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх;

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд Нийгмийн даатгалын ерөнхий газар, түүний харьяа 33 байгууллага, Нийгмийн даатгалын сангийн 31 салбар эрх, нийт 238 хэрэглэгчээр хандан нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын шилэн дансны мэдээллийг төсөв, гүйцэтгэлийн 9, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын 5, бусад 7, нийт 21 төрлийн мэдээллийг байршуулж, хэрэглэгч, ажил олгогч, иргэд, олон нийтэд нээлттэй танилцах боломжийг бүрдүүлж Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Шилэн дансны мэдээлэл байршуулалтын мэдээг дараах байдлаар харууллаа.

/Өссөн дүнгээр/

Байршуулалт	2021 оны	2022 оны 1	2022 оны 2	2022 оны 3
-------------	----------	------------	------------	------------

		жилийн эцэс		дүгээр улирал		дугаар улирал		дугаар улирал	
		Мэдээллийн тоо	Хувь	Мэдээллийн тоо	Хувь	Мэдээллийн тоо	Хувь	Мэдээллийн тоо	Хувь
Нийт мэдээллэвэл зохих мэдээллийн тоо		10,069		2,501		4,807		7,503	
Үүнээс	Хугацаанд нь мэдээллэсэн	9,357	92.9	2,358	94.3	4,567	95.0	7,120	94.9
	Хугацаа хоцроосон	674	6.7	128	5.1	214	4.5	330	4.4
	Мэдээллээгүй	38	0.4	15	0.6	26	0.5	53	0.7
Мэдээллээгүй	Төсөв, гүйцэтгэл	17	44.7	7	46.7	11	42.3	31	58.5
	Хөрөнгө оруулалт	12	31.6	8	53.3	5	19.2	5	9.4
	Бусад	9	23.7	0	0.0	10	38.5	17	32.1

Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагуудын шилэн дансны мэдээлэл байршуулалт:

- 2021 оны жилийн эцсийн байдлаар 99,6 хувь;
- 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар 99,4 хувь;
- 2022 он 2 дугаар улирлын байдлаар 99,4 хувь;
- 2022 он 3 дугаар улирлын байдлаар 99,2 хувьтай байна.

Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагуудын шилэн дансны мэдээлэл байршуулалтын 2021 оны жилийн эцэс, 2022 оны 1, 2, 3 дугаар улирлын байдлаар мэдээг гаргаж, тайланг Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яаманд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 1/83, 1/672, 1/1320, 1/1817 дугаар албан бичгээр хүргүүлэв.

1.2. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх зорилтын хүрээнд:

1.2.1. Төсвийн ерөнхийлөн захирагч /Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд/-аас төсвийн шууд захирагч /Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга/-тай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулах;

Төсвийн ерөнхийлөн захирагч /Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд/-аас Төсвийн шууд захирагч /Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга/-тай 2022 онд байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд эхний хагас жил болон жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ үнэлгээг хийсэн.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 10 зорилтын 67 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнд:

- Бодлогын баримт бичигт тусгагдсан 1 зорилт, 13 арга хэмжээ;
- Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийн 1 зорилт, 22 арга хэмжээ;
- Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийн 4 зорилт, 17 арга хэмжээ;

- Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах чиглэлээр 4 зорилт, 15 арга хэмжээ байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг:

- Эхний хагас жилийн байдлаар **93,2** хувиар;
- Жилийн эцсийн байдлаар **94,8** хувиар дүгнэж “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан үнэлгээний тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 01/1187, 01/2344 дүгээр албан бичгээр болон цахимаар Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн.

1.2.2. Төсвийн шууд захирагч /Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга/-аас зохион байгуулалтын нэгжийн дарга /менежер/-тай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулах;

Төсвийн шууд захирагч /Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга/-аас зохион байгуулалтын нэгжийн дарга нартай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд 2021 оны жилийн эцэс, 2022 оны эхний хагас жил, жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээг хийлээ.

Зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга нарын 2021, 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хэрэгжүүлэхээр тусгасан зорилт арга хэмжээг дараах байдлаар харууллаа.

Нэгжийн нэр	2021 он		2022 он	
	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо
Тамгын газар	3	30	3	30
Дотоод аудит, мониторингийн газар	3	32	6	16
Бодлогын хэрэгжилт, судалгааны газар	3	32	2	22
Сургалт олон нийт, хамтын ажиллагааны газар	3	9	3	9
Хяналт шалгалтын газар	3	8	2	12
Санхүү бүртгэлийн газар	2	15	2	17
Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс	4	38	4	30
Мэдээллийн технологийн төв	2	22	2	14
Нийт	23	186	24	150

Зохион байгуулалтын нэгжүүдийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний биелэлтийн дунджийг:

- 2021 оны жилийн эцсийн байдлаар **94,4** хувь;
- 2022 оны эхний хагас жилийн байдлаар **93,4** хувь;
- 2022 оны жилийн эцсийн байдлаар **93,4** хувиар дүгнэж, үнэлгээний тайлан, дүгнэлт зөвлөмжийн хамт Тамгын газарт хүргүүлсэн болно.

1.2.3. Аймаг /нийслэл/, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс /газар/-ийн төсвийн шууд захирагчтай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дүгнэлт зөвлөмж гаргах;

Төсвийн төвлөрүүлэн захирагч /Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга/-аас төсвийн шууд захирагч /Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга/-тай 2021, 2022 онд байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд 2021 оны жилийн эцсийн байдлаар болон 2022 оны эхний хагас болон жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ үнэлгээг хийсэн.

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга нарын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 4 зорилтын 43 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнд:

- Бодлогын баримт бичигт тусгагдсан 2 зорилтын 19 арга хэмжээ;
- Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах чиглэлээр 4 зорилтын 13 арга хэмжээ;
- Хуулиар тусгайлан олгосон болон нийтлэг чиг үүргийн 2 зорилтын 5 арга хэмжээ байна.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан нийт зорилт, арга хэмжээний биелэлтийг 2021 оны жилийн эцсийн байдлаар 85.7 хувиар дүгнэсэн бөгөөд зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч байгаа хэдий ч үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай гэж дүгнэсэн.

2. Нийслэлийн Нийгмийн даатгалын газрын дарга, Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга нарын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 8 зорилтын 44 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Тус гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг газар тус бүрээр нь харуулбал:

№	Зорилтын төрөл	Газар	Арга хэмжээний тоо
1	Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт	Бодлогын хэрэгжилт, судалгааны газар	3
2	Хуулиар тусгайлан олгосон нийтлэг чиг үүргийн зорилт	Санхүү бүртгэлийн газар	17
3	Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийн зорилт	Хяналт шалгалтын газар	5
4		Дотоод аудит, мониторингийн газар	2
5	Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт	Сургалт, олон нийт хамтын ажиллагааны газар	3
6		Тамгын газар	9
7		Эмнэлэг хөдөлмөр магадлах комисс	3
8		Мэдээллийн технологийн төв	4
Нийт арга хэмжээний тоо			44

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын аймгийн Нийслэлийн Нийгмийн даатгалын газрын дарга, нийгмийн даатгалын хэлтсийн дарга нартай байгуулсан 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг /эхний хагас жилийн байдлаар дунджаар/ **86.9** хувь, жилийн эцсийн байдлаар дунджаар/ **87.5** хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлж дүгнэж, дүгнэлт, зөвлөмж, үнэлгээний тайланг Тамгын газарт хүргүүлсэн.

1.3. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж холбогдох байгууллагад хүргүүлэх;

1.3.1. Төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;

“Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтэд 2021 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Монгол Улсын Их Хурлын 2015 оны 53 дугаар тогтоолоор баталсан Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого /2015-2030 он/-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нийгмийн даатгалын чиглэлээр хэрэгжүүлэхээр 6 зорилтын 45 арга хэмжээ тусгагдсан байна. Үүнд:

- Тэтгэврийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлэх ажлын хүрээнд 3 үйл ажиллагаа;
- Олон давхаргат тэтгэврийн тогтолцоог бүрдүүлэх ажлын хүрээнд 21 үйл ажиллагаа;
- Малчин, хувиараа болон албан бус хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын хүрээнд 5 үйл ажиллагаа;
- Тэтгэврийн нас, тэтгэвэр тогтоох хөнгөлөлттэй нөхцөлийн тухайд 4 үйл ажиллагаа;
- Тэтгэврийн даатгалын шимтгэлийн талаар 4 арга хэмжээ;
- Нийгмийн даатгалын байгууллагын тогтолцоог бэхжүүлэх ажлын хүрээнд 7 арга хэмжээг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний биелэлтийг 2021 оны жилийн эцсийн байдлаар **97.9** хувиар дүгнэж, үнэлгээний тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 1/188 дугаар албан бичгээр Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн.

1.3.2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нийгмийн даатгалын чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд 2021 оны жилийн эцэс, 2022 оны эхний хагас жилийн байдлаар холбогдох тайлан, мэдээ, мэдээллийг үндэслэн хяналт-шинжилгээ үнэлгээг хийсэн.

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2021, 2022 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нийгмийн даатгалын чиглэлээр бодлого, зорилт, арга хэмжээг дараах байдлаар харууллаа.

Бодлого	2021			2022 оны эхний хагас жил			2022 оны жилийн эцэс		
	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь
Нийт	6	8	100	6	9	86,6	5	7	77.5

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2021, 2022 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нийгмийн даатгалын чиглэлээр тусгагдсан бодлого, зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцыг:

- 2021 оны жилийн эцсийн байдлаар **100 хувь** буюу **Үр дүнтэй** буюу зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд хүрсэн, удирдлага зохион байгуулалтын ажил бүрэн хийгдсэн, тодорхой үр дүн гарсан;

- 2022 оны эхний хагас жилийн байдлаар **86.6** хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн”;
- 2022 оны жилийн эцсийн байдлаар **77.5** хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлж, үнэлгээний тайланг дүгнэлт зөвлөмжийн хамт Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн.

1.2.3. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;

Монгол улсын их хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд 2022 онд нийгмийн даатгалын чиглэлээр хэрэгжүүлэхээр 2 зорилт бүхий 4 арга хэмжээ тусгагдсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийгмийн даатгалын салбарт хэрэгжүүлэхээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцыг 2022 оны жилийн эцсийн байдлаар 77.5 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлж, үнэлгээний тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 1/2468 дугаар албан бичгээр Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн.

1.2.4. Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;

Монгол Улсын Их хурлын 2021 оны 56 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд 2022 онд нийгмийн даатгалын чиглэлээр хэрэгжүүлэхээр 1 зорилт бүхий 1 арга хэмжээ тусгагдсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд нийгмийн даатгалын салбарт хэрэгжүүлэхээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцыг 2022 оны жилийн эцсийн байдлаар 70.0 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлж, үнэлгээний тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 1/2468 дугаар албан бичгээр Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн.

1.2.5. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нийгмийн даатгалын чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;

Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийгмийн даатгалын чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний биелэлтэд 2021 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Төрийн байгууллага, албан тушаалтан, хувийн хэвшил, иргэний нийгмийг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх, ил тод, нээлттэй, хариуцлагатай нийгмийг хөгжүүлэх зорилгоор Авлигын эсрэг үйл ажиллагааны 2021 оны төлөвлөгөөнд нийгмийн даатгалын чиглэлээр 6 зорилтын 17 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгагдсан байна.

Төлөвлөгөөнд тусгагдсан ажил үүргийг зохих түвшинд биелүүлсэн тул нийт арга хэмжээний биелэлтийн дунджийг **98.7** хувь буюу Бүрэн хангалттай гэж дүгнэж, тайланг Тамгын газарт хүргүүлсэн.

ХОЁР. САЛБАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД МОНИТОРИНГ ХИЙХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

2.1. Тэтгэвэр тогтоох, олгох, өөрчлөх, дараалал, үйл ажиллагаанд мониторинг хийх;

Нийслэлийн төвийн 6 дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн тэтгэвэр тогтоох, олгох, өөрчлөх үйл ажиллагаанд “Төвийн 6 дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн ажлын байранд хийсэн ажиглалт, судалгааны ажил”-ын мэдээ, судалгаа, тайланг үндэслэн дүн шинжилгээ хийлээ.

Шинжилгээгээр Нийслэлийн төвийн 6 дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсүүд нь даатгуулагчдад тэтгэвэр тогтоох, олгох, өөрчлөх үйлчилгээг дараах **2** байдлаар үзүүлж байна. Үүнд:

- Хан-Уул (хариуцсан хороогоор), Сонгинохайрхан (хороо харгалзахгүй) дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн тэтгэврийн байцаагч тэтгэврийн баримт, бичгийг хүлээн авч шалган, тэтгэвэр тогтоодог;
- Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдийн хувьд тэтгэврийн баримт, бичиг хүлээн авах, тэтгэвэр тогтоох, хянах зэрэг ажил үүргийг тус бүр нэг байцаагч гүйцэтгэж байна.

Энэхүү дүн шинжилгээгээр одоо хэрэгжиж буй тэтгэвэр тогтоон олгож байгаа үйл ажиллагааны давуу болон сул талыг тодорхойлж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг боловсруулан удирдлагад танилцуулсан.

2.2. Нийгмийн даатгалын байгууллагаас 2023 онд өндөр насны тэтгэвэрт гарах албан хаагчдад олгох нэг удаагийн тэтгэмжид мониторинг хийх;

Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ыг үндэслэн Нийгмийн даатгалын ерөнхий газрын Тамгын газраас ирүүлсэн Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагын ажилтнуудын 2023 онд өндөр настны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийн тооцооллыг ажилтнуудын хөдөлмөрийн дэвтэр, нийгмийн даатгалын дэвтэр, ажилд томилсон, чөлөөлсөн тушаал, холбогдох архивын лавлагаа, цалингийн тооцооны карт, нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн сантай тулган нягталлаа.

Тус ажлын хүрээнд 51 албан хаагчид 1,157,9 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж олгох нэрсийн жагсаалтыг холбогдох тооцооллын хамт Бодлого хэрэгжилт, судалгааны газар хүргүүлсэн.

2.3. Нийгмийн даатгалын төв орон нутгийн байгууллагуудын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтэд мониторинг хийх;

Үндэсний аудитын газраас нийгмийн даатгалын төв орон нутгийн байгууллагуудын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нэгтгэж, дүгнэлээ.

Аудитаар 7.7 сая төгрөгийн 9 акт, 4,542.5 сая төгрөгийн 29 албан шаардлага, 12,396.6 сая төгрөгийн 54 зөвлөмж ирүүлсэн ба актын биелэлт 82.8 хувь, албан шаардлагын биелэлт 53.5 хувь, зөвлөмжийн биелэлт 40.6 хувьтай байна.

Акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг 2022 оны 7 дугаар сард Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд цахимаар хүргүүлсэн ба 2022 оны 10 дугаар сарын 15-ны өдөр Үндэсний Аудитын газрын www.fas.audit.mn цахим хуудас /Санхүүгийн тайлангийн аудитын систем, акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлт бүртгэх/-д биелэлтийг нотлох баримтын хамт байршуулсан болно.

2.4. “Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд баримтлах журам”-ын дагуу өгсөн үүрэг даалгаврын биелэлтэд мониторинг хийх;

Мэргэжлийн хяналтын байгууллагаас аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсүүдэд Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хууль түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журмын хэрэгжилтэд 2021 онд хяналт шалгалт хийгдсэн.

Тус шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал, мэргэжлийн хяналтын байгууллагын улсын байцаагчийн тогтоосон акт, хүргүүлсэн албан шаардлага, зөвлөмжийг аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсүүдээс гаргуулан авч нэгтгэсэн.

Уг нэгтгэлээр 53 аж ахуйн нэгжийн давхардсан тоогоор 637 даатгуулагчийн 141,2 сая төгрөгийн дэмжлэг, 16 даатгуулагчид 11,8 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг буцаан санд төлүүлэх, 9 даатгуулагчид 1,8 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг нөхөн олгох акт тогтоож, илэрсэн зөрчлийг арилгуулахаар 4 дүүрэг, 5 аймгийн Нийгмийн даатгалын хэлтэст албан шаардлага хүргүүлсэн байна

Иймд дээрх илэрсэн зөрчлийг арилгах, холбогдох заавар, журмын хэрэгжилтийг хангуулах зорилгоор аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсүүдэд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 1/809 дүгээр зөвлөмжийг хүргүүлж, биелэлтийг 2022 оны 06 дүгээр сарын 15-ний өдрийн дотор Нийгмийн даатгалын ерөнхий газрын Дотоод аудит, мониторингийн газарт ирүүлэхийг үүрэг болгосон ба биелэлтийг нэгтгэж, удирдлагад 7 дугаар сард танилцуулсан болно.

2.5. Нийгмийн даатгалын зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн чиг үүрэгт дүн шинжилгээ хийж, санал, дүгнэлт боловсруулах;

Нийгмийн даатгалын ерөнхий газруудын чиг үүргийн давхардлыг арилгах, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, чиг үүргийн хуваарилтын уялдаа, давхцал, хийдлийг нягтлан шалтгааныг тодорхойлж, шийдлийн талаарх санал дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж удирдлагад танилцуулах зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий газрын чиг үүрэгт дүн шинжилгээг хийж гүйцэтгэлээ.

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын чиг үүрэгт өөрчлөлт орж, Нийгмийн даатгалын ерөнхий газар байгуулагдан бүтэц, орон тоо шинэчлэн батлагдсантай холбогдуулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2018 оны “Нийгмийн даатгалын ерөнхий газрын нэгжүүдийн чиг үүргийг шинэчлэн батлах тухай” А/27 дугаар тушаалаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын чиг үүргийг шинэчлэн баталсан байна.

Тус тушаалаар байгууллагын үндсэн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхээр дотоод зохион байгуулалтын нэгжийн 9 газар 204 төрлийн чиг үүргийг баталжээ. Үүнд:

- Дотоод аудит, мониторингийн газар: 2 чиглэлээр 13 чиг үүрэг;

- Тамгын газар: 8 чиглэлээр 68 чиг үүрэг;
- Бодлогын хэрэгжилт, судалгааны газар: 3 чиглэлээр 27 чиг үүрэг;
- Санхүү бүртгэлийн газар: 3 чиглэлээр 21 чиг үүрэг;
- Хяналт шалгалтын газар: 1 чиглэлээр 16 чиг үүрэг;
- Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс: 1 чиглэлээр 10 чиг үүрэг;
- Сургалт, олон нийт, хамтын ажиллагааны газар: 3 чиглэлээр 29 чиг үүрэг;
- Мэдээллийн технологийн төв: 1 чиглэлээр 13 чиг үүрэг;
- БНСУ дахь нийгмийн даатгалын үйлчилгээний алба: 1 чиглэлээр 7 чиг үүрэг;

Ажил үүргийн шинжилгээг дараах чиглэлийн дагуу хийж гүйцэтгэсэн.

- Давхардсан чиг үүрэг байгаа эсэх;
- Байгууллагын үндсэн зорилт, чиг үүргүүд нь нэгж, хэлтсийн чиг үүргүүдэд бүрэн хуваарилагдаж орсон эсэх /орхигдсон/;
- Чиг үүрэгт тусгагдсан боловч хийгддэггүй ажлууд;

Чиг үүрэгт хийсэн байгууллагын түвшний үйл явцын шинжилгээгээр байгууллагын бүтцийн нэгжийн чиг үүргийг албан тушаалын тодорхойлолт, үйл ажиллагааны төлөвлөгөө, хийгдэж буй ажлуудтай уялдуулан шинэчлэх шаардлагатай гэж дүгнэж, зөвлөмжийн боловсруулж удирдлагад 2022 оны 12 дугаар сард танилцуулсан болно.

2.6. Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох, эрх сэргээх, эрх баталгаажуулах шалгалтад орох байцаагч, ажилтнуудын нэрсийн жагсаалтад мониторинг хийж, ажлын хэсэгт хүргүүлэх;

Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох, баталгаажуулах, сэргээх шалгалтыг 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс 20-ны өдрүүдэд улсын хэмжээнд бүсчлэн зохион байгуулсан.

Энэхүү ажлын хүрээнд улсын байцаагчийн шалгалтад орох нийт 491 ажилтнуудын нэрсийн жагсаалтад 2022 оны 10 дугаар сарын 17-ны өдрөөс 26-ны өдрүүдэд Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/27 дугаар тушаалаал батлагдсан “Нийгмийн даатгалын улсын /ахлах/ байцаагчийн эрх олгох, эрх баталгаажуулах, эрх сэргээх шалгалтын журам”-ын 4.2 дахь заалтын дагуу шалгалтад орох болзол шалгуурыг хангасан эсэхийг Нийгмийн даатгалын байцаагчаар ажилласан хугацааны нотлох баримт, дипломын хуулбар, сүүлийн 2 жилийн төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэжлийн түвшинг үнэлсэн үнэлгээ, хэлтсийн даргын “А, Б” тушаал зэрэг бичиг баримттай тулган нягталж, ажлын хэсэгт хүргүүлсэн.

2.7. Нийгмийн даатгалын төв орон нутгийн байгууллагуудад хүргүүлсэн хариутай бичиг, үүрэг даалгаврын биелэлтэд дүн шинжилгээ хийж, санал, дүгнэлт боловсруулах;

Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагуудад хүргүүлсэн хариутай бичиг, хугацаатай үүрэг даалгаврын биелэлтэд дүн шинжилгээ хийлээ.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын нийт 7 газраас 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд төв орон нутгийн байгууллагуудад 133 албан бичиг хүргүүлснээс 44 албан бичиг нь хариутай байна.

Дүн шинжилгээгээр цаашид ажилдаа хийж хэвшүүлэх шаардлагатай ажлын саналыг тайлан мэдээний хамт удирдлагад танилцуулсан.

2.8. Төвийн 6 дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн ажлын байранд хийсэн ажиглалт, судалгааны ажил;

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны А/48 дугаар тушаалаар баталсан удирдамжийн дагуу төвийн 6 дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн ажлын байранд дүн шинжилгээ хийх, ажилтнуудын ажлын ачааллыг тодорхойлох, ажил үүргийн давхардал болон ажлын цагийн алдагдлыг илрүүлж түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох зорилгоор ажлын байрны ажиглалт, судалгааг хийж гүйцэтгэсэн.

Ажлын байранд хийсэн зураг авалтын дүн мэдээнээс харахад байцаагч ажилтнууд өдөрт дунджаар 510.1 мин ажиллаж байгаа бөгөөд үүнээс 87.3 хувь буюу 445.5 минутыг ажлын байранд нийгмийн даатгалын үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.

Нийслэлийн төвийн 6 дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүд батлагдсан бүтэц орон тоогоор ажиллаж байгаа хэдий ч Хан-Уул, Сонгинохайрхан, Сүхбаатар, Чингэлтэй, Баянгол дүүргүүд одоо ажиллаж байгаа дотоод зохион байгуулалт, цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан ажлын ачаалал ихтэй ажлын байран дээр дахин зохион байгуулалт хийж байцаагч нарыг тодорхой хугацаанд шилжүүлэн ажиллуулах, нэг байцаагчид ногдох ажлын ачааллыг тэнцвэржүүлж ажиллуулах шаардлагатай байгаа бөгөөд дүүрэг тус бүр дээр хүн амын тоо, ажил олгогч, даатгуулагчийн тоо, тэтгэвэр авагчийн тоо зэргийг харгалзан, бүтэц орон тоог дахин батлуулж, үйл ажиллагааны зураглалыг шинэчлэн гаргаж мөрдөж ажиллах нь зүйтэй гэж дүгнэсэн.

Энэхүү ажиглалт, судалгааны дүн мэдээг нэгтгэн, санал боловсруулж, удирдлагад танилцуулсан.

2.9. Нийгмийн даатгалын байгууллагын ажилтнуудын албаны и мэйл ашиглалтын байдалд судалгаа хийх;

Нийгмийн даатгалын байгууллагын ажилтнуудын албаны и мэйл ашиглалтын байдалд 2022 оны 10 дугаар сарын 10-ны байдлаар судалгаа хийлээ.

Тус судалгаагаар аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсүүдэд албаны и мэйл ашиглаж байгаа бүртгэлтэй 2,167 ажилтан байгаагаас 62,4 хувь буюу 1,352 ажилтан ашиглаж байна.

Дээрх албаны и мэйл хаягтай боловч одоо нийгмийн даатгалын төв, оон нутгийн байгууллагуудад ажиллаагүй /жирэмсэн болон амаржсаны тэтгэмж, хүүхэд асрах чөлөөтэй байгаа ажилтнуудаас бусад/ хаягийг хаалгахаар нэрсийн жагсаалтыг гаргаж, Мэдээллийн технологийн төвд хүргүүлээ.

ГУРАВ. САЛБАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ДОТООД АУДИТ ХИЙХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

3.1. Батлагдсан удирдамжийн дагуу малчнаар ажиллаж байсан хугацааг тогтоох “Сум, дүүргийн Засаг даргын дэргэдэх орон тооны бус байнгын зөвлөл”-ийн тогтоолд аудит хийж, зөвлөмж өгөх, тайлагнах;

1. Даатгуулагчийн малчнаар ажиллаж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тодорхойлох зөвлөлийн дүрмийн хэрэгжилт, даатгуулагчийн малчнаар ажиллаж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тодорхойлсон зөвлөлийн тогтоолын үндэслэлд нийцлийн аудит хийх бэлтгэл ажлын хүрээнд Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсүүдээс “Даатгуулагчийн малчнаар ажиллаж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тодорхойлох зөвлөл”-өөр даатгуулагчийн малчнаар ажиллаж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тодорхойлсон иргэдийн судалгааг 21 аймаг, 9

дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсүүдээс гаргуулан авч 2022 оны 05 дугаар сард нэгтгэсэн.

Судалгаагаар тус зөвлөлөөр 2018 онд 1,655, 2019 онд 1,033, 2020 онд 3,299, 2021 онд 1,578, 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 437 нийтдээ 8,002 иргэний малчнаар ажиллаж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тодорхойлсон байна.

2. Даатгуулагчийн малчнаар ажиллаж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тодорхойлох зөвлөлтийн дүрмийн хэрэгжилт, даатгуулагчийн малчнаар ажиллаж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тодорхойлсон зөвлөлийн тогтоолын үндэслэлд аудит хийх тухай 2022 оны “Нийцлийн аудит хийх” 04/04 дүгээр удирдамжийг боловсруулан батлуулж, Архангай, Төв, Сүхбаатар, Увс, Ховд аймгийн Нийгмийн даатгалын хэлтсүүдэд 2022 оны 10 дугаар сарын 11-ны өдөр цахимаар хүргүүлсэн.

Дээрхи удирдамжид заасан зөвлөлийн хурлын тогтоол, тэмдэглэл, холбогдох баримт, бичгийг цахимаар хүлээн авсан.

3.2. 2019, 2020 оны Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагад ажилласан нийгмийн даатгалын орон тооны бус төлөөлөгчийн орон тоо, цалингийн олголтод мониторинг хийсэн дүнг нэгтгэх, зөвлөмж хүргүүлэх;

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2017 оны “Журам батлах тухай” 24 дүгээр тогтоол, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн “Нийгмийн даатгалын төлөөлөгчийн орон тоо батлах тухай” А/03 дугаар тушаалыг үндэслэн мониторинг хийсэн.

Мониторингийг дараах чиглэлийн дагуу хийсэн. Үүнд:

- Батлагдсан орон тоо;
- Батлагдсан төсөв, гүйцэтгэл;
- Ажилтантай байгуулсан гэрээ, ажлын гүйцэтгэлийг үнэлэх;
- Ажиллах хүчний хөдөлгөөн;

Мониторингийн дүнг нэгтгэн удирдлагад хүргүүлсэн ба илэрсэн зөрчил, дутагдлыг арилгаж, цаашид давтан гаргахгүй байх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, холбогдох тогтоол, журмын хэрэгжилтийг хангуулах зорилгоор аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсүүдэд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны “Зөвлөмж хүргүүлэх тухай” 01/382 дугаар албан бичгээр зөвлөмж хүргүүлж ажилласан.

Тус зөвлөмжийн биелэлтийг 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсээс 2022 оны 09 дүгээр сарын 30-ний өдрийн байдлаар гаргуулан авч нэгтгэж удирдлагад 2022 оны 11 дүгээр сард танилцуулсан.

3.3. Батлагдсан удирдамжийн дагуу аймаг /нийслэл/, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс /газар/-ийн Шилэн дансны тухай хуулийг хэрэгжилтэд аудитын дүнг нэгтгэх, зөвлөмж хүргүүлэх;

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийх аудитын удирдамжийн дагуу аудитыг дараах чиглэлийн дагуу гүйцэтгэсэн. Үүнд:

- Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т заасан байгууллага буюу Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагууд нь шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж мэдээлсэн эсэх;

- Хуулийн 6 дугаар зүйлийн 6.7-д заасан Нийгмийн даатгалын сангийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж мэдээлсэн эсэх;
- Хуулийн 8 дугаар зүйлд заасан холбогдох албан тушаалтан хяналтыг хэрэгжүүлж, өмнөх аудитаар өгсөн албан шаардлага зөвлөмжийг биелүүлсэн эсэх;
- Хуулийн 8 дугаар зүйлийг үндэслэн Байгууллага, албан тушаалтны ажлын тайланг дүгнэх, дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийхдээ энэ хуулийн хэрэгжилтийг гол үзүүлэлт болгосон эсэх;

Тус аудитаар шилэн дансны цахим хуудсанд 2021 онд байршуулсан мэдээлэл дараах байдалтай байна.Үүнд:

➤ *Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагуудын хувьд:*

Нийгмийн даатгалын байгууллагын мэдээлэл байршуулалт нийт 34 хэрэглэгчээс 5,066 мэдээлэл мэдээлэхээс 4,419 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, мэдээлэл байршуулалт 94,18 хувь. Үүнээс:

- Хугацаанд нь мэдээлээгүй буюу хугацаа хоцроосон 363 мэдээлэл байгаа нь нийт мэдээллийн 7,17 хувь;
- Мэдээлээгүй буюу дутуу мэдээлсэн 565 шийдвэрийн 10,4 тэрбум төгрөгийн 284 мэдээлэл байгаа нь нийт мэдээллийн 5,61 хувийг эзэлж байна.

➤ *Нийгмийн даатгалын сангийн хувьд:*

Нийгмийн даатгалын сангийн мэдээлэл байршуулалт нийт 32 хэрэглэгчээс 5,003 мэдээлэл мэдээлэхээс 4,273 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, мэдээлэл байршуулалт 93,50 хувь. Үүнээс:

- Хугацаанд нь мэдээлээгүй, хугацаа хоцроосон 422 мэдээлэл байгаа нь нийт мэдээллийн 8,43 хувь;
- Мэдээлээгүй буюу дутуу мэдээлсэн 26,910 шийдвэрийн 5,155.83 тэрбум төгрөгийн 308 мэдээлэл байгаа нь нийт мэдээллийн 6,16 хувийг эзэлж байна.

Аудитын дүн мэдээг нэгтгэж, холбогдох газрын дарга нарт танилцуулан, цаашид авах арга хэмжээний саналыг Тамгын газарт хүргүүлсэн болно.

3.4. Дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн 2021 оны нийгмийн халамжийн зарим төрлийн үйлчилгээний хэрэгжилтэд хийсэн дотоод аудит;

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны “Хяналт шалгалтын ажил зохион байгуулах тухай” А/87 дугаар тушаалаар баталсан “Нийгмийн халамжийн зарим төрлийн үйлчилгээний хэрэгжилтэд хяналт шалгалт хийх” удирдамжийн дагуу 2022 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс 05 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

Энэхүү шалгалтад Баянгол, Сүхбаатар, Сонгинохайрхан, Чингэлтэй, Хан-Уул дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс хамрагдсан ба 2021 оны жилийн эцсийн байдлаар халамжийн сангаас ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгосон хөнгөлөлт, зардлыг анхан шатны баримтын бүрдэлтэй тулган шалгасан.

Энэхүү аудитын дүн, мэдээг нэгтгэж, санал дүгнэлт боловсруулан ажлын хэсэгт удирдамжид заасан хугацаанд нь хүргүүлсэн.

ДӨРӨВ. САЛБАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ АЖЛЫН ХҮРЭЭНД:

4.1. Жирэмсний болон амаржсаны тэтгэмжийн тогтоолт, олголт, шилжүүлэгт хяналт тавих;

Тэтгэмжийн даатгалын сангаас олгож байгаа жирэмсний болон амаржсаны тэтгэмжийн тогтоолт, олголтыг санхүүгийн анхан шатны баримт, шилжүүлгийн гүйлгээтэй тулган шалгах, илэрсэн зөрчлийг арилгах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, чиглэл зөвлөмж өгөх, цаашид авах арга хэмжээний саналыг гаргах зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны “Жирэмсний болон амаржсаны тэтгэмжийн тогтоолт, олголт, шилжүүлсэн байдалд хяналт шалгалт хийх тухай” удирдамжийг 21 аймгийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд хүргүүлсэн.

Шалтгалтыг дараах асуудлын хүрээнд нэгтгэсэн. Үүнд:

- Анхан шатны баримтын бүрдлийг үнэн, зөв бүрдүүлж байгаа эсэх;
- Жирэмсний амаржсаны тэтгэмж олгосон жагсаалтыг анхан шатны баримттай тулган шалгах;
- Тэтгэмжийн байцаагч шалгаж баталгаажуулсан баримт бичиг, тэтгэмж олгох жагсаалтыг сангийн нягтлан бодогч, ахлах нягтлан бодогч, хэлтсийн даргаар хянуулан баталгаажуулсан эсэх;

Илэрсэн зөрчлийг арилгаж цаашид давтан гаргахгүй байх талаарх саналыг боловсруулж, шалгалтын нэгдсэн дүнг удирдлагад танилцуулсан.

4.2. Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсүүдийн төрийн сан болон арилжааны банкны төвлөрсөн харилцахын орлогын хувиарлалт, төвлөрүүлэлтэд хяналт тавих;

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2016 оны “Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн урсгалыг зохицуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/51 дүгээр тушаал, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2019 оны “Тушаалд өөрчлөлт оруулах тухай” А/121 дүгээр тушаалын хэрэгжилтийг нягтлав.

Судалгааг хийх явцад сангийн харилцах дансны үлдэгдлийг сар бүрийн эцэст бүрэн хуваарилж тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн Санхүү бүртгэлийн тасгийн дарга болон орлогын нягтлан бодогч нарт зөвлөж, дүнг удирдлагад танилцуулав

4.3. Ажилтнуудын цагийн бүртгэлд хяналт тавьж, санал, дүгнэлт боловсруулах;

Дотоод аудит, мониторингийн газрын нэмэлт ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын ажилтан, албан хаагчдын 2022 оны 10 дугаар сарын байдлаарх цагийн бүртгэлд хяналт тавьж, дүн шинжилгээ хийлээ.

Цаашид ажилтан, албан хаагчдын хоцорсон, тасалсан, бүртгэл хийгээгүй хугацааны ирцийг үнэн зөв гаргаж хариуцлага тооцдог болох, ажлын ачаалал ихтэй илүү цагаар ажилладаг албан хаагчдад хууль тогтоомжид заасны дагуу илүү цагийн хөлс олгох, цагийн бүртгэлийг цалин олголттой уялдуулж, ажлын цаг ашиглалтыг сайжруулах шаардлагатай гэж дүгнэсэн.

Дүн шинжилгээнд үндэслэн цагийн бүртгэл, цаг ашиглалтыг сайжруулж хэрэгжүүлэх санал, дүгнэлтийг боловсруулж удирдлагад танилцуулсан

ТАВ. БУСАД АЖЛЫН ТАЛААР:

5.1. Иргэд, даатгуулагч, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлтэд хариу, зөвөлгөө өгөх;

Тайлант хугацаанд Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллага болон ажил олгогч, харилцагч бусад байгууллагаас тус газарт хандаж 64 албан бичиг, иргэд, даатгуулагчаас 24 өргөдөл ирүүлсэн байна.

Энэхүү өргөдөл, гомдол, хүсэлтийг хуулийн хугацаанд нь бүрэн шийдвэрлэж ажилласан.

5.2. “Тэтгэмж тогтооход шаардагдах баримт бичгийг бүрдүүлэх, хянах журам”-ыг боловсруулан батлуулж төв, орон нутгийн нийгмийн даатгалын байгууллагыг мэргэжил, арга зүйгээр ханган ажиллах;

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны эмнэлгийн хуудсыг цахимаар олгож эхэлсэнтэй холбогдуулан тэтгэмж тогтоож, олгох үйл ажиллагааг түргэн шуурхай, чирэгдэлгүй үзүүлэх зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны “Журам батлах тухай” А/72 дугаар тушаалаар “Тэтгэмж тогтооход шаардагдах баримт бичгийг бүрдүүлэх, хянах журам”-ыг боловсруулан батлуулсан.

Уг журмыг Хууль зүй, дотоод хэргийн яам Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянаж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 5822 дугаарт бүртгэн, Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем www.legalinfo.mn цахим хуудсанд байршуулсан ба батлагдсан журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах талаар чиглэлийг Дотоод аудит, мониторингийн газрын даргын 2022 оны “Шийдвэр хүргүүлэх тухай” 04/909 дугаар албан бичгээр аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд хүргүүлсэн.

5.3. “Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай” хуулийн хэрэгжилтийг хангах;

“Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг хэрэгжүүлэх журам”-ын 5.2-т “Энэ журмын 5.1-т заасан үнэт цаасыг эзэмшигч тэтгэвэр авагч нь үнэт цаасыг гуравдагч этгээдэд худалдан борлуулах, аливаа бусад хэлбэрээр шилжүүлэхгүй ба зөвхөн өвлүүлэх эрхтэй” гэж заасан.

Үнэт цаас эзэмших эрхтэй тэтгэвэр авагчдаас 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш нас барж, үнэт цаасыг ар гэрийн хүнд нь өвлүүлэх 8,537 нас барсан иргэд байснаас 2022 оны 12 дугаар сарын 12-ны байдлаар 7,207 иргэний ар гэрт 6,756.5 сая төгрөгийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв”-өөр дамжуулан олгоод байна.

Харин 1,330 нас барсан иргэдийн ар гэрт 1,061.5 сая төгрөгийг олгоогүй байна.

5.4. Нийгмийн даатгалын байгууллагад тоон гарын үсгийг нэвтрүүлэх;

Цахим гарын үсгийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, журмын хэрэгжилтийг ханган, нийгмийн даатгалын байгууллагад тоон гарын үсгийг нэвтрүүлж, түүнийг ашиглах зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий газар, “Үндэсний Дата Төв” УТҮГ-тай хамтран 2022 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн БА/429, НД-52/22 дугаар “Тоон гарын үсгийн гэрчилгээ олгоход хамтран ажиллах гэрээ”-г байгуулсан.

Хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны А/130 дугаар тушаалаар “Е-токен төхөөрөмж ашиглах заавар”-ыг баталж Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагад хүргүүлсэн.

Нийгмийн даатгалын байгууллагын хэмжээнд нийт 1,157 ажилтан албан хаагчдын Э-токен төхөөрөмжийн эрхийг авч, ашиглахад бэлэн болсон.

ДОТООД АУДИТ, МОНИТОРИНГИЙН ГАЗАР